



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 07 сарын 06 өдөр

Дугаар А/56

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2017 оны 01/19 дүгээр тогтоолоор батлагдсан Нийслэлийн Эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 1-50, Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/505 тоот захирамж, тус газрын дүрмийн 2.5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Богдхан уулын Төрхурх-Цэцээ гүн чиглэлийн явган аяллын замыг тохижуулах ажилд хяналт тавих, хүлээж авах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, шаардагдах төсвийн задаргааг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Явган аяллын замын тохижилтын ажилд шаардагдах төсөв болох 44 875 566 /дөчин дөрвөн сая найман зуун далан таван мянга таван зуун жаран зургаа/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг ахлах нягтлан бодогч /Б.Батбаатар/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА *D. Batsu* Д.БАТСҮХ



• 1150500183

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2018 оны 07
сарын 06 өдрийн А/56 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

5284325 СБТ 8936 1118263502

БОГДХАН УУЛЫН ТӨРХУРХ-ЦЭЦЭЭ ГҮН ЧИГЛЭЛИЙН ЯВГАН АЯЛЛЫН
ЗАМЫГ ТОХИЖУУЛАХ АЖИЛД ХЯНАЛТ ТАВИХ, АЖЛЫГ ХҮЛЭЭЖ
АВАХ АЖЛЫН ХЭСГИЙГ БҮРЭЛДЭХҮҮН

Комиссын дарга	В.Батчимэг	/ Бодлого, төлөвлөлтийн хэлстийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /
Гишүүд	Б.Ербахыт	/ Статистик, сургалт, судалгаа хариуцсан мэргэжилтэн /
	Б.Ишдорж	/ Дотоодын аялал жуулчлал, бүтээгдэхүүний хөгжил хариуцсан мэргэжилтэн /
	Ш.Ундармаа	/ Соёлын аялал жуулчлал, салбарын хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн /
	Б.Батбаатар	/ Ахлах нягтлан бодогч /

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2018 оны 07
сарын 06 өдрийн А/56 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

108425 СЭТ-3706 1118263562

ТӨРХУРХ-ЦЭЦЭЭ ГҮН ЧИГЛЭЛИЙН ЯВГАН АЯЛЛЫН
ЗАМЫГ ТОХИЖУУЛАХ

2018 оны 07 дугаар сарын 06-ны өдөр

Улаанбаатар хот

№	Зардлын зүйл	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Ажиллах хүчний зардал	-	8 227 246	8 227 246
2	Материал	-	26 705 331	26 705 331
3	Тээвэр	-	226 452	226 452
4	Машин ашиглалт	-	77 589	77 589
5	Нэмэгдэл зардал	-	4 508 048	4 508 048
6	НӨАТ	-	3 974 467	3 974 467
7	Нормчлолын сан	-	71 540	71 540
8	Захиалагчийн албаны зардал	-	-	-
9	Инженер хайгуул, зураг төсөл	-	290 000	290 000
10	Магадлашгүй ажил	-	794 893	794 893
11	Бусад нэмэлт зардал	-	0	0
Нийт			44 875 566	